



## **“ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ ТОГТООХ ИТГЭЛЦҮҮР БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд тус хуулийн 57 дугаар зүйлийн 57.9 дэх хэсэгт “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.” гэж, мөн зүйлийн 57.10 дахь хэсэгт “Энэ хуулийн 57.9-д заасан албан тушаалын цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрт Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч хамаарахгүй.” гэж тус тус заасан. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын 2011 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр”-ийг шинэчлэн батлах шаардлага бий болсон.

Төрийн өндөр албан тушаалтанд хамаарах зарим улс төрийн болон тусгай албан тушаалтны цалингийн хэмжээг салбарын хуулиар нь зохицуулсан байдаг. Тухайлбал, Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт “Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.” гэж, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт “Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурал тогтооно.” гэж, Прокурорын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэгт “Прокурорын албан тушаалын цалингийн сүлжээ, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.” гэж, Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхий аудиторын цалин, зэрэг зиндааг Улсын Их Хурал тогтооно.” гэж тус тус заасны дагуу Авлигатай тэмцэх газар, шүүх, прокурор, аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны цалингийн хэмжээг Улсын Их Хурал тусгайлан тогтоож байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 85 дугаар тогтоолоор Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоосон.

Гэтэл дээрх байгууллагын удирдах албан тушаалтнууд нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтнуудад тооцогддог тул цалингийн итгэлцүүр тогтоох заалтад давхар хамаарч байна. Тиймээс төрийн өндөр албан тушаалтны

зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрт Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос гадна Авлигатай тэмцэх газар, шүүх, прокурор, аудитын байгууллагын удирдах албан тушаалтнууд хамаарахгүй байхаар зохицуулах шаардлагатай байна.

**Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь дараахь заалтыг агуулна:

1.Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Төрийн аудитын байгууллагын дарга, дэд даргаас бусад төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг хавсралтаар батлахаар тусгана.

2.Тогтоол гарсантай холбогдуулан “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай заалтыг тусгана.

**Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар**

Яамны төрийн нарийн бичгийн даргын албан тушаалын сарын цалингийн хамгийн өндөр шатлалд хамаарах цалингийн хэмжээг суурь болгож, төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг баталдаг. Иймээс төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ нь яамны төрийн нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн сүлжээний хамгийн өндөр шатлалын цалингийн хэмжээтэй уялдана .

Түүнчлэн энэхүү тогтоол батлагдсаны дараа зарим төрийн тусгай албан тушаалтнуудын цалингийн хэмжээг Улсын Их Хурал ялгаатай байдлаар тогтоож байгаа давхардал арилж, итгэлцүүрт хамаарах албан тушаалтнууд тодорхой болно.

**Дөрөв.Тогтоолын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Энэхүү тогтоолын төслийг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2011 оны “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” 36 дугаар тогтоолыг хүчингүй болгоно.